



ЮАНЬ УЛСЫН ДУУРЬЛИГИЙН ХУУЧИН ҮГИЙН ОРЧУУЛГАД ОРЧУУЛГЫН
ТАЙЛБАРЛАХ АРГЫГ АШИГЛАХ ТУХАЙ

Ш. Эгшиг³³, Bai Tingting³⁴

Abstract: Yuan Play (元曲) is a literary genre written in the 13th-14th centuries, and it retains the characteristics of the medieval language in its literary style and historical narrative (典故).

In the article take sentences with Mongolian words from Yuan Plays as an example, and proposes a method of glossing the archaic words in the sentence based on historical documents. The article demonstrates the usefulness of adding explanations, footnotes, and the use of translation glossing/footnoting methods when translating archaic chinese words preserved in sentences with the words "hudag, gudamj, hishigten, mori, buurch, ulaach, bogtag". It also demonstrates the Mongolian loanwords introduced into Chinese such as "hudag, gudam, sauha, dah" with real examples in Yuan Plays.

Түлхүүр үг: Юань улсын дуурьлиг, монгол үг бүхий өгүүлбэр, хуучин үг, ормол үг, тайлбар хийх арга

Удиртгал

Бид энэхүү өгүүлэлд хятадын судлаач Фан Линггүй(方龄贵)-ийн “Юань, Мин улсын ший дуурьлигийн монгол хэл (元明戏曲中的蒙古语)” номыг эх хэрэглэгдэхүүн болгож, энэ номд буй монгол үг орсон хятад өгүүлбэрийг орчуулах хийгээд тухайн өгүүлбэрүүдэд монгол үг орж хэрэглэгдэхдээ утгын өөрчлөлт хэрэв гарсан бол орчуулагч нь монгол онцлог, үндэстний ахуй соёлыг хадгалан, тухайн утгыг алдагдуулахгүйгээр хэрхэн зохистойгоор буулгах, мөн орчуулагч хятад хэлний түүхэн үлгэр домог, дуурьлигийн зохиолд гарсан түүхэн хүн, үйл явдлын талаар сайтар судалж, дундад зууны үеийн үгийн утга, ойлголт, ухагдахуунд тайлбар зүүлт хийж, өнөөгийн уншигчдад тайлбар хийх нь зүйтэй болох талаар саналаа дэвшүүлэв.

Юуны өмнө уг өгүүлэлд эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан ном болон зохиогчийн талаар товчхон танилцуулъя. 2014 онд “Юань, Мин улсын ший дуурьлигийн монгол хэл” ном олны харааны хүртээл болжээ. Юань улсын дуурьлигт орсон монгол үгийг өгүүлбэртэй нь ялган авч, монгол үгийн үүсэл гарлын талаар нарийн тайлбар хийсэн анхны бүтээлийн зохиогч бол монгол

³³ МУИС, Ази судлалын тэнхим, дэд профессор

³⁴ Гадаад хэл шинжлэлийн доктор

үндэстний профессор Фан Лингуй бөгөөд тэрээр 1918 онд Жилинь мужийн Горлосын Монгол үндэстний Өөртөө Засах хошуунд төрсөн хүн юм. 1938-1942 онд Баруун өмнөд үндэсний их сургуулийн түүхийн ангид суралцаж, энэ хугацаанд профессор Яо Цун-ү (姚从吾)-гийн “Ляо, Жинь, Юань гүрний түүх” болон профессор Шао Шюньжөн(邵循正)-гийн “Юань гүрний түүх”-ийг тус тус сонгон суралцсан бөгөөд энэ үеэс монголын түүхийг судлах сонирхолтой болсон нь энэхүү номыг бичих суурь дэвсгэрийг нь тавьжээ. Сургуулиа төгсөөд Бээжингийн Их Сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн түүхийн тэнхимд элсэн орж, профессор Яо Цун-ү болон Шао Шюньжөн нарын удирдлага доор Монголын түүх, Юань улсын түүхийн мэргэжлээр суралцаж, 1946 онд магистрын зэрэгтэй болжээ. Тэрээр Юньнаний их сургуулийн утга зохиол, түүхийн тэнхимийн багш, Күнъманий багшийн их сургуулийн (одоогийн Юньнаний багшийн их сургууль) түүхийн тэнхимийн багш, дэд профессор, профессор, тэнхимийн эрхлэгчээр удаа дараалан ажилласан юм. Монголын түүх (蒙古史), Юаний түүхийн сурвалжийн судалгаа(元史文献学), түүх судлал (史料学), ялангуяа “Монголын Нууц Товчоон(蒙古秘史)”, “Тун жы тiao гө (通制条格)(Юань улсын төрийн хууль, цаазын баримт бичгийн эмхэтгэл)”, Юань улсын дуурьлиг, Юань улсын гэрэлт хөшөөний бичээс зэрэг түүхэн сурвалжид чиглүүлэн судалгаа хийсээр иржээ.

Өгүүллийн сэдэвт холбогдуулан “Юань улсын дуурьлиг” хэмээх нэр томъёоны талаар товч тайлбар хийе. “Юань улсын дуурьлиг” нь Юань гүрний үед цэцэглэн хөгжсөн утга зохиолын нэгэн шинэ жанр хэлбэр бөгөөд тухайн үед зарим хүн үүнийг “домоги (传奇)” хэмээн нэрлэдэг байжээ. Тан улсын үед үүссэн “дуурьлиг” хэмээх дуурийн урлагийн ерөнхий ойлголт болон Сүн, Алтан улсын дуурьлигаас ялгахын тулд “Юань улсын дуурьлиг (元曲)”, “Юаний зажюй (元杂剧)” гэж ялган нэрлэжээ. Хөгжмийн найруулгын хувьд “Юань улсын дуурьлиг” нь хойд зүгийн хөгжимд тулгуурлан зохиогдсон учир “Хойд зажюй (北杂剧)” хэмээн нэрлэсэн учиртай. “Юань улсын дуурьлиг” бол хятад хэлээр зохиогдсон жүжгийн зохиолын хэлбэртэй, дуулалт жүжиг бөгөөд энэ нь ая, шүлгийн ая дан тохирсон байхын дээр мөн акробат, хошин шог жүжгийн элементийг хослуулсан театрын олон төрөл зүйлийг нэгэн дор цогцлуулсан театр урлаг юм. Зөвхөн Юань улсын үед цэцэглэн хөгжсөн төрөл төдийгүй дуурьлигийн зохиолууд нь уран зохиолын бие даасан жанр болж хөгжжээ. Энэ жанр оргүй хоосноос гарч ирээгүй, Тан, Сүнгийн үеийн яруу найраг, шүлгийн суурин дээр Юань улсын нийслэл Дадү (Бээжин)-д анх үүссэн театрын урлаг бөгөөд монголчууд өмнөд Сүн улсыг нэгтгэсний дараа нийт хятад даяар тархан дэлгэрсэн уран зохиолын нэгэн төрөл гэж үзэж болно.

Нэгэн түүхэн үеийн алдарт уран зохиолын төрөл болох дуурьлигийн зохиолд тухайн үед цөөнгүй монгол үг орсон бөгөөд түүний тухай судалгаа олны анхаарлыг татсаар ирсэн юм. Монгол үгийн гарал үүслийн тухай нотолсон баримт олон гарсан боловч монгол үг бүхий өгүүлбэрт суурилж хийсэн орчуулгын тухай судалгаа цөөн юм. Үүнд, Юань улсын дуурьлигт орсон монгол үгийн талаар судлагдсан байдлыг тоймлон авч үзвэл, Жу Жюй-и (朱居易) -гийн “Юаний жүжгийн энгийн хэл ярианы аман аялгууны тайлбар жишээ (元剧俗语方言例释)”, /Худалдааны хэвлэлийн хороо, 1956/, Гү Шюэже(顾学颉)-гийн “Юань улсын дуурьлигийн тайлбар бичиг(元曲释词)” гурван боть,

/Хятадын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, 1983, 1984, 1988)/, Фан Лингүй (方龄贵)-гийн бичсэн “Юань, Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл (元明戏曲中的蒙古语)”, уг ном гарсны дараа бичсэн “Юань, Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэлний нэмж олдсон үгс (元明戏曲中的蒙古语拾补), Гао Минкай (高名凯), Шы Ёувэй(史有为)-гийн “Хятад хэлний харь үгийн толь бичиг (汉语外来词词典)” /Шанхайн толь бичгийн хэвлэлийн хороо, 1998 он/ Ши Юунже(席永杰)-гийн “Юань ба Мин улсын ший дуурьлиг дахь цөөн тоот үндэсний хэл (关于元明戏曲中的少数民族)”/ “Зуу уд” Монгол багшийн дээд сургуулийн сэтгүүл, 2000 он/ зэрэг бүтээлийн дотроос Фан Лингүй (方龄贵)-гийн туурвисан “Юань, Мин улсын ший дуурьлиг дахь монгол хэл (元明戏曲中的蒙古语)” хэмээх ном нь монгол үгийг жагсаан оруулсан бөгөөд гарал үүслийн талаар нарийн тайлбар хийсэн анхны бүтээл юм. Энэхүү судалгааны өмнө өрнөдөд ч тухайлан Юань улсын дуурьлигийн монгол үгийн тусгай судалгаа бараг гараагүй гэхэд болно. Ер нь монгол үгийн үүсэл гарлын судалгаа ховор байгаа тул дуурьлигийн зохиолыг гадаад хэлнээ орчуулах буюу түүнд буй хуучин үгийн орчуулгын арга барилын талаар авч үзэх хэрэгтэй болж байна.

Уран зохиолын орчуулгын арга барил

Уран зохиолын орчуулга хийх арга барилыг эрдэмтэн судлаачид олон талаас нь авч үзээд өөр өөрсдийнхөөрөө тайлбар хийсэн байна. Эрдэмтэн Р. Гүрбазар ерөнхийд нь бүрэн төгс, үгчилсэн, хялбарчилсан, тайлбарласан гэсэн дөрвөн хувилбарыг санал болгосон байдаг (1996:111-112). Түүний тогтоосноор бүрэн төгс орчуулга гэдэг нь “Уншигч орчуулгын зохиолыг уншаад эх зохиолыг уншсантай адил уран сайхны мэдрэмжийг авахуйц агуулга санааг бүрэн илэрхийлсэн, утга болон найруулгын хувьд оновчтой, хоёр хэлний өвөрмөц шинж, хэм хэмжээг чанд баримтлан орчуулахыг хэлнэ. Энэ аргаар орчуулга хийхэд орчуулагчийн хоёр хэлний мэдлэг өндөр байхаас гадна үгэнд уран, эх зохиолыг туурвисан улс түмний түүх соёл, ахуй амьдрал, зан заншилд нэвтэрхий байхыг шаарддаг. Бүрэн төгс орчуулга соёлын болон уран зохиолын өв болон уламжлагддаг байхад үгчилсэн орчуулга нь аажимдаа мартагддаг. Учир нь энэ төрлийн орчуулга болхи бөгөөд тухайн улс үндэстний соёлын хөгжилд ашиг тус болдоггүйтэй холбоотой. Харин хялбарчилсан орчуулга гэдэг нь томоохон зохиол бүтээлийг олны хүртээл болгох зорилгоор найруулгыг нь энгийн ойлгогдохуйц болгох арга юм. Ихэвчлэн танин мэдэх ба сургалтад зориулан тухайн мэргэжлийн дагнасан орчуулагч хлбарчилсан орчуулга хийдэг. Уншигчдад ойлгомжтой байлгах үүднээс эх зохиолд гарах үндэстний онцлог үг хэллэг, далд утга агуулга зэргийг тайлбарлан орчуулна. Ингэснээр уншигчид тус бүтээлийн утга агуулгыг бүрэн дүүрэн ойлгох ч, найруулгын яруу тансаг чанар нь алдагддаг байна. Тиймээс уран зохиолын орчуулгад энэ аргаас зайлсхийх нь зүйтэй.”(1996:111-112) хэмээн тодорхойлсон байна.

Эрдэмтэн Ж. Баттөр “Орчуулагчийн тайлбар орон судлалтай холбогдох нь” хэмээх өгүүлэлдээ “...орчуулж буй хэлнээ байхгүй реали үг, нэр томьёо, түүхт хүний нэр, үйл хэрэг, түүх, соёл иргэншлийн ухаглахуун бүхий үг хэллэг гарч ирэх ийм үед ‘Орчуулагчийн тэмдэглэл’ хэмээх аргазүйг ашигладаг юм. ‘Орчуулагчийн тэмдэглэл’ гэдгийг нэг талаас орчуулагчийн тайлбар ч гэж нэрлэж болох агаад нөгөө талаас уншигч, судлаач нэрт уг бичвэрийг ойлгож мэдэхэд нь туслах чанартай, товч тодорхой мэдээлэл ч гэж хэлж болно.” (2012: 15) хэмээн тайлбарлан орчуулах арга

барилын талаар онцолжээ.

Юань улсын дуурьлигт буй “Түүхэн домог яриа бол түүхэн гэрч бөгөөд ачаалагч юм. Үүний тухай орчуулахад агуулсан далд утгад нь зүүлт тайлбар хийнэ. Ингэхэд хүрвэл, хятад соёлын мэдээллийг нөгөө соёлд дамжуулан хүргэхэд оршино. Гэхдээ зүүлт эшлэлийг элуулэч бөуран зохиолын орчуулга хийхэд боломжтой ашиглавал зохино.” (Wang nan, 2016: 34) хэмээн тайлбарласан байна. Ер нь юань улсын дуурьлигийг анх англи хэл рүү орчуулсан хүн бол Жон Фрэнсис Дэвис (John Francis Davis) бөгөөд 1827 онд Ма Жы-юань(马致远)-нь “Лао шөн эр(老生儿)”-ийг “An Heir in his old Age” Хөгшин насандаа залгамжлагч болсон нь гэж тайлбарлан буулгаж, дуурьлигийн орчуулгын анхны үүдийг нээн, оршил хэсэгтээ орчуулга хийх нь бүрэн төгс орчуулгын хувилбарыг уншигчдад хүргэхэд оршино.” гэж гол зорилго болгон дэвшүүлсэн байна.

Бид дээрх дэвшүүлсэн саналтай санал нийлж байгаа бөгөөд уран зохиолын орчуулга хийхэд уншигч болгонд агуулга санааг төгс төгөлдөр дамжуулах үүднээс бүрэн төгс орчуулгын арга барилыг дээдлэхийн сацуу өгүүлбэрт орсон түүхэн холбогдолтой үг хэллэг, хуучин үгийг уншигч орчуулгын зохиолыг уншаад эх зохиолыг уншсантай адил бүрэн төгс ойлгохын үүднээс тайлбарлан орчуулах буюу зүүлт тайлбар хийх нь зүйтэй болов уу.

Судалгааны аргазүй

Энэхүү өгүүлэлд Юань улсын дуурьлигийн монгол үг бүхий өгүүлбэрийн доторх хуучин үгийн үгчлэн орчуулсан, тайлбар зүүлт хийсэн орчуулгын хувилбарыг харьцуулан үзэж, нэн ойлгомжтой болгох үүднээс хүснэгтлэн харьцуулж дүгнэлт гаргав. Мөн дундад зууны үеийн уран зохиолд монгол үг орж хэрэглэгдэх үеийн утга өөрчлөгдсөн үзэгдэлд соёлын ялгааны тайлбар хийж, голдуу ажиглах, харьцуулах, тайлбар зүүлт хадах, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн болно.

Нэг. Хуучин үгийг тайлбарлан орчуулах нь

Юань улсын дуурьлигийн зохиол XIII-XIV зууны үед зохиогдсон учраас тухайн үед бичигдсэн зохиолын өгүүлбэрийг монгол хэлнээ орчуулахад хоёр үндэстний хэлийг сайн эзэмшсэн, түүхийн домог яриа, зан заншил, соёлыг сайн мэддэг байхаас гадна нэр томъёог зөв зохистой оноох, далд утгыг нь сайн ойлгож буулгадаг чадвартай байх хэрэгтэй болно. Жишээлбэл,

1. 武汉臣《玉壶春》南吕一枝花曲：“我是个翠红堆傅粉的何郎，花胡画眉的张敞。” Ү Ханьчэнь-ийн “Юй ху чүн” дуурьлигийн ‘Нань люй и жы хуа’ дуунд “Би бол Цүй Хун эмсийн хүрээлэнд нүүр буддаг Хө лан, Хуа гудамжинд хөмсөг зурдаг Жан Чан юм.”

Үүнд, “何郎 he lang” гэдэг нь “三国魏驸马何晏，仪容俊美，平日喜修饰，粉白不去手，行步顾影，人称“傅粉 何郎。后即以“何郎”称喜欢修饰或面目姣好的青年男子。” Гурван улсын нэг Вэй улсын тавнан Хө Янь, гоё сайхан царайлаг төрхтэй, хэзээд гоёж гоодох дуртай, оо энгэсгээ гараасаа салгадаггүй, явдал мөр нь сэхүүн дээгүүр зантай тул, хүмүүс түүнийг “нүүрэндээ оо энгэсэгтэй Хө Лан” хэмээн нэрлэдэг болжээ. Хожим нь “Хө Лан” гэдэг нь үс зүсээ засах дуртай, эсвэл царай зүс сайхантай залуу эрэгтэй хүнийг заадаг.” болсон байна.

“翠红堆 cui hong dui 花胡同 hua hu tong” гэсэн нь “妓院, 享乐的地方。” хэмээх “Эмсийн хүрээлэн буюу зугаа цэнгэлийн газар”-ыг заажээ.

“张敞 zhangchang” 是汉朝时期，京兆尹（中国古代官名）张敞为官没有官架子，经常在散朝

后步行回家。他和他的太太感情很好，因为他的太太幼时受伤，眉角有了缺点，张敞每天都为了他的妻子画眉毛，而且技艺十分娴熟，画出的眉毛十分漂亮，汉宣帝为此将他们树立夫妻恩爱的典范。Жан Чан (zhang chang) бол Хань улсын үед Жин Жао-инь (эртний хятадын зэрэг тушаалын нэр) хэмээх түшмэл хүн байсан бөгөөд түшмэлийн ларжаа маяггүй, хурал тарсны дараа ихэвчлэн гэртээ алхаж хариад, эхнэртэйгээ маш сайн эе найрамдалт харилцаатай. Эхнэр нь багадаа бэртэж гэмтсэн тул хөмсөг нь гажигтай байсан юм. Жан Чан эхнэрийнхээ хөмсгийг өдөр бүр маш чадварлаг будаж, будсан хөмсөг нь гоё үзэмжтэй байдаг байжээ. Шюаньди хаан энэ байдлыг нь мэдээд тэднийг гэр бүлийн хайрын үлгэр жишиг болгон хүмүүст дуурайл болгосон байна.

Энэхүү өгүүлбэрт буй оноосон нэр “何郎 (he lang)”, “张敞 (zhangchang)”, “翠红堆 cui hong dui”, “花胡同 hua hu tong” бол түүхэнд болсон үйл хэрэг, домог ярианаас сэдэвлэсэн тул энэ тухай сайн ойлгохгүйгээр шууд нэр томъёог үгчлэх буюу галиглан буулгахад уншигчид ер нь цаад түүхэн учир шалтгаантай утгыг нь ойлгохгүй, зөвхөн уншаад өнгөрөх төдий, ямар ч суугдал төсөөлөл үлддэг байна. Уран зохиолын орчуулгад энэ мэтийн түүхэн хэрэг явдлыг далд агуулсан утга санаа нь өнөөгийн хүмүүс ойлгохгүй, тухайн цаг үед амьдарч байсан хүмүүс сайн ойлгодог хуучин үг багагүй тохиолддог учраас уншигчдад нэн ойлгомжтой байлгахын үүднээс тайлбарлан орчуулах аргыг ашиглах нь зүйтэй.

Хүснэгт 1:

Хятад өгүүлбэр	Үгчлэн орчуулах	Дэвшүүлсэн хувилбар
我是个翠红堆傅粉的何郎，花胡同画眉的张敞。	Би бол Цүй Хун дүй-д нүүр буддаг Хө лан, Хуа худагт хөмсөг зурдаг Жан Чан юм.	Би бол эмсийн хүрээлэн (Цүй Хун дүй)-д нүүр буддаг Хө лан, эмсийн хүрээлэн-д (Хуа гудамж) хөмсөг зурдаг Жан Чан юм.

Энэ жишээнд бүхий өгүүлбэрийн монгол үг бол 胡同 хэмээн дуурьлигт орсон “худаг, гудам, гудамж” гэх үг юм. Тэр цагийн нэг өрх эсвэл хэсэг өрх айл нэг худаг тойрон оршин суух тул тэр хэсэг газрыг нэг худгийнхан, нэг гудмынхан гэж ойлгож байснаас монгол “худаг” гэдэг үгийг дуудлагаар нь хятад үсгээр тэмдэглэж, улмаар хятад хэлэнд орсон ормол үг болой.

2. 刘时中《散曲》：“佯薛回家去，一个个欺凌亲戚，眇视乡闾。” Лю Шижунгийн “Сань чюй” дуурьлигт: “Хишигтэн гэр рүүгээ харьж, хамаатан саднаа нэг нэгээр нь дарамталж, ойр зэргэлдээ айлын хүнийг доор үзмүй.”

Үүнд, 乡闾-г тайлбарлая. 古以二十五家为“闾”，一万二千五百家为“乡”，因以“乡闾”泛指民众聚居。Эрт дээр үед хорин таван өрхийг нэг “闾 lü” гэж, арван хоёр мянга таван зуун өрхийг нэг сум “乡 xiang” гэж нэрлэдэг ажээ, Иймээс “乡闾 xiang lü” нь ерөнхийдөө олон айл өрхийн хамт суурьшин амьдардаг газрыг заадаг. Энэхүү нэр томъёоны тус тусын утгыг ухаж олохын суурин дээр “乡闾 xiang lü” нийлэмж үг нь олон тоог илэрхийлж, монгол хэлэнд орчуулахад тайлбар хийж бичвэл хүмүүс утгыг гуйвуулахгүй сайн мэдэхийн сацуу мэдлэгээ дээшлүүлэхэд тустай гэж үзэв.

Хятад өгүүлбэр

怯薛回家去，一个个欺凌
亲戚，眇视乡间

Үгчлэн орчуулах

Че шюэ гэртээ харьж,
хамаатан саднаа нэг нэгээр
нь дарамталж, шян луй -
гээ доор үзмүй.

Дэвшүүлсэн хувилбар

Хишигтэн гэртээ харьж,
хамаатан саднаа нэг нэгээр
нь дарамталж, ойр зэргэлдээ
айлын хүнийг доор үзмүй.

Энэ жишээнд бүхий өгүүлбэрийн монгол үг бол *怯薛薛* гол дуурьлигт орсон “хишигтэн” гэх үг юм.

3. 《席上腐谈》：“向见官妓舞柘枝，戴一红物，体长而头尖，俨如靴形，想即是今之罽蛄也。” “Ши шан фү тань” дуурьлигт: “Хайрт бие үнэлэгчид уламжлалт ёсны жөжы бэлхүүсний бүжгийг бүжиглэхэд, урт бие, шовх толгойтой, гутлын хэлбэртэй улаан юм зүүсэн, бодоход одоогийн хөхөл юм байна.”

Үүнд: “官妓 guan ji” 古代供奉官员的妓女。Эрт дээр үед албан тушаалтнуудыг асрах биеэ үнэлэгчдийг зааж, “柘枝舞 zhe zhi wu” нь唐代西北民族舞蹈。最初为女子独舞，舞姿矫健，节奏多变，大多以鼓伴奏。后来有双人舞，名《双柘枝》。“Жөжы” бэлхүүсний бүжиг нь Тан улсын үеийн баруун хойд орны ардын бүжиг. Эхэндээ эмэгтэйчүүд бие даан бүжиглэж, эрч хүчтэй, олон янзын хэмнэлтэй бөгөөд ихэвчлэн бөмбөр дагалдан бүжиглэдэг. Сүүлд нь “Давхар Жөжы” хэмээн хоёр хүн хамт тоглох бүжиг болон хөгжжээ.



Үндэстний соёл урлагийн хэлбэр болох “Жөжы” бэлхүүсний бүжиг нь Тан улсын хөгжил цэцэглэлтийн цаг үеийг төлөөлж байсан, бүжиглэх хэв маяг нь хурц хөдөлгөөнтэй, сүр хүч төгс, дэгжин цоморлог урлагийн төрөл болно. “Жөжы”-бүжигтэй сайн танилцаж, энэ тухай шимтэн уншигч болгонд соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс нэр томьёоны тухай тайлбар хийх нь зүйтэй юм.

Хятад өгүүлбэр

向见官妓舞柘枝，戴一红
物，体长而头尖，俨如靴
形，想即是今之罽蛄也

Үгчлэн орчуулах

Хайрт бие үнэлэгчид
уламжлалт ёсны жөжы
бүжгийг бүжиглэхэд,
урт бие, шовх
толгойтой, гутлын
хэлбэртэй улаан юм
зүүсэн, бодоход
одоогийн хөхөл юм
байна

Дэвшүүлсэн хувилбар

Хайрт бие үнэлэгчид уламжлалт
ёсны жөжы бэлхүүсний бүжиг
(Тан улсын үеийн баруун хойд
орны ардын бүжиг)-ийг
бүжиглэхэд, урт бие, шовх
толгойтой, гутлын хэлбэртэй
улаан юм зүүсэн нь зүйрлэвээс
одоогийн *богтаг* юм байна

Энэ жишээнд бүхий өгүүлбэрийн монгол үг бол 𠬞𠬞 хэмээн дуурьлигт орсон “богтаг” гэх үг юм.

4.《破天阵》剧一折：“金宿白：论俺番将，不好步行。则骑抹邻。”“По тянь жэнь” дуурьлигийн нэгдүгээр үзэгдэлд, “Жинь сү өгүүлэх нь: Манай жанжин (番将 范ьжян)-ы тухай өгүүлбэл, алхаж явахдаа тааруу, харин морь л унаж явдаг юм.”

《岳飞精忠》剧一折：“那颜瘸着腿，小番耳又聋，卜儿赤一只眼，兀刺赤豁着唇。”“Юэ фэй жин жун” дуурьлигийн нэгдүгээр үзэгдэлд, “Ноёны хөл нь доголон, бичгийн түшмэл (小番 小范) нь чих дүлий, буурч нь нэг нүдтэй, улаач нь сэтэрхий уруултай.” гэжээ.

Дээрх хоёр өгүүлбэрт буй “番将 fan jiang”-ыг 古代的一个称谓, 用来指非汉族的将领 гэх хятад тайлбар нь “Эртний цол хэргэмийн нэрийдэл, хятад бус үндэстний жанжныг заана.” гэсэн үг юм. “小番 xiao fan”-ыг хятад хэлээр 旧时泛指外国或国内少数民族 хэмээн тайлбарласан нь “Эрт дээр үед ихэвчлэн гадаад улс орон буюу дотоодын цөөн тоот үндэстний бичгийн ажил эрхэлдэг албан тушаалтнууд, цэргүүдийг хэлнэ.” гэсэн тайлбар юм. Үүнд, хятад хэлний “番 fan” хэмээх үгийн тухай мөшгин үзэхэд анх “西周 Баруун Жөү” улсын үед түүхэн баримт бичигт тэмдэглэсэн бөгөөд сүүлд нь харь үндэстэн (番族 fan zu) хэмээх тусгай цөөн тоот үндэстэн оршиж, иймээс “番 fan” хэмээх үгтэй нийлж бүтсэн нийлэмж үг буй “番将 fan jiang”, “小番 xiao fan”, “番官 fan guan” нь хятад үндэстнээс бусад улс орны буюу өөр бусад үндэстний зэрэг тушаалын холбогдолтой нэрийдэл болж хөгжсөн байна. Мөн хожим нь “番 fan” үгээр бүтсэн нийлэмж үг харь газар(番地 fan di), баруун хойд хил дагуух үндэстэн (诸番 zhu fan), гадаадтай харилцаа байгуулах (通番 tong fan), харийн бичгийн зүйл (番文 fan wen), харь хүн (番人 fan ren), харь хэл (番语 fan yu), харь хөгжим (番乐 fan yue), харь ном(番书 fan shu), харь мөнгө(番银 fan yin) зэрэг нь бүгд харь улс оронтой холбогдох нэр томъёог илэрхийлсэн байдаг.

Хятад өгүүлбэр

论俺番将，不好步行。则
骑抹邻

Үгчлэн орчуулах

Манай Фаньжяны тухай
өгүүлбэл, алхаж явахдаа
тааруу, харин морь л
унаж явдаг юм

Дэвшүүлсэн хувилбар

Харь жанжин (Фаньжян)-ы
тухай өгүүлбэл, алхаж
явахдаа тааруу, харин морь л
унаж явдаг юм.

那颜瘸着腿，小番耳又
聋，卜儿赤一只眼，兀刺
赤豁着唇

Ноёны хөл нь доголон,
шяофань нь чих дүлий,
буурч нь нэг нүдтэй,
улаач нь сэтэрхий
уруултай

Ноёны хөл нь доголон,
бичгийн түшмэл (шяофань)
нь чих дүлий, буурч нь нэг
нүдтэй, улаач нь сэтэрхий
уруултай

Энэ 2 өгүүлбэрийн жишээнд бүхий гурван монгол үг бол 抹邻, 卜儿赤, 兀刺赤 хэмээн дуурьлигт орсон “морь”, “буурч”, “улаач” гэх үгс юм.

Хоёр. Утгын хувиралд зүүлт тайлбар хийх

Юань улсын дуурьлигт орсон монгол үг хэллэг нь уугуул монгол хэлэнд байгаа үндсэн утга нь

хятад хэлэнд орж хэрэглэгдэхдээ хувирч, орж байгаа хэлний нөлөөнд багагүй орсон байна. Эдгээр үгийг үгчлэн буюу утгачлан орчуулахдаа далд утгыг нь илрүүлэн, зүүлт тайлбар хийх нь зүйтэй юм.

1. Худаг: Монгол хэлний газрыг гүнзгий ухаж гаргасан устай нүх буюу “худаг” хэмээх үг хятад хэлэнд орж хэрэглэгдэхдээ хот зээлийн “гудамж” гэх утгаар хэрэглэгдсэн тухай олон судлаачид судалгаа хийсэн байна. “Худаг” хэмээх үг Юань улсын дуурьлигийн өгүүлбэрт орж хэрэглэгдэхдээ “гудамж” гэх утга нь нэн нарийсаж тусгай нэрийдлийг заасан тухай дэлгэрэнгүй авч үзвэл,

1. 武汉臣《玉壶春》南吕一枝花曲：“我是个翠红堆傅粉的何郎，花胡同画眉的张敞。” Ү Ханьчэньгийн “Юй ху чүн” дуурьлигийн ‘Нань луй и жы хуа’ дуунд “Би бол Цүй хун дүйд нүүр будах Хө лан, Хуа гудамж(янхны газар)-нд хөмсөг зурах Жан Чан юм.”

关汉卿《单刀会》剧三折：“你孩儿到那江东，旱路里摆着马军，水路里摆着战船，直杀个血胡同。” Гуань Ханьчингийн “Дань дао хуй” дуурьлигийн гуравдугаар үзэгдэлд: “Таны хүүхэд голын зүүн талд очиход, хуурай замд морин цэрэг жагсаж, усан замд байлдааны хөлөг онгоц байрлаж, алалдан тулалдсаар цусан гудамж (цуст зам) шиг зам гарав.”

Монгол хэлний “худаг” хэмээх үг нь Юань улсын дуурьлигт орж хэрэглэгдэхдээ “血胡同 цусан гудамж”, “花胡同 хуа гудамж” гэдэг нь дайн байлдаанаас үүссэн цуст зам ба янхны гудамж (утга шилжин биеэ үнэлэгчийн оршин суух газар, янхны газар)-ыг заажээ. “血胡同 цусан гудамж” гэх нийлэмж нь монгол хэлний үндсэн утга нь болох амьжиргаанд хэрэгцээтэй ‘усны худаг’ гэх утга нь өөрчлөгдөөд шинэ утгат буюу цус бүрхсэн ‘гудамж’ болж хувирчээ. “花胡同 хуа гудамж” буюу “эмсийн хүрээлэн” гэхээр утга нь нэн нарийсаж, 花 гэх үгийн нэг салаа утга болох биеэ үнэлэх утгатай холбоотойгоор тухайн гудам бие үнэлэгчдийн гудамж гэсэн орон байрыг заасан тусгай нэрийдэл болон шинэ утгыг илэрхийлсэн байна.

2. Сауха: “撒和(саух)” хэмээх үгийг “сауха хууч: ‘дайны олз омог’, ‘бэлэг’” (Төмөртоогоо 2018, 224) гэж монгол хэлний үгийн гарлын тольд тайлбарлажээ. Монголын Нууц Товчооны үсгийн галиг 114-р зүйлд: “Өэлүн эхэд өгсөн бэлэг” (Сумъяабаатар 1990, 119) гэж тохиолддог бол Юань улсын дуурьлигт,

《西厢记》剧一本一折末白：“安排下饭，撒和了马，等着哥哥回家。” “Ши шян жи” дуурьлигийн нэгдүгээр үзэгдлийн төгсгөлд: “Хоолонд орсны дараа, морио идүүлэнгээ (сауха), ахыгаа гэртээ ирэхийг хүлээнэ.”

《冻苏秦》剧二折孛老白：“……时遇暮冬天气，风又大雪又紧，十分寒冷。大的个孩儿，他撒和头口去了。” “Дун сү чинь” дуурьлигийн хоёрдугаар үзэгдэлд, Бо Лао өгүүлэх нь: “Өвлийн сүүл сарын билгийн тооллын арван хоёрдугаар сард, салхи цас ихтэй, туйлын тэсхим хүйтэнд том хүү, малаа тэжээх(сауха)-аар явжээ.”

Энд тохиолдсон “撒和头口 sa he tou kou” “撒和了马 sa he le ma” гэсэн “сауха” гэсэн үг хятад өгүүлбэрийн найруулгын орчинд үйл үгийн үүрэг гүйцэтгэж, тусагдахуун болох ‘үхэр, адуу зэрэг гэрийн тэжээвэр амьтанд өвс тавих, идүүлэх’ гэх утгаар хэрэглэгдсэн байна. Уг үгийн утгын хувьд монгол уугуул хэлэндээ ‘бусдаас авах буюу ямар нэг зүйлийг олж авах’ хэмээх утгатай байсан бол

хятад зохиолд утгыг эсрэгээр өөрчлөн ‘бусдад өгөх, өөрөөс гаргах’ гэсэн утгаар хэрэглэсэн нь ажиглагдаж байна. Өгүүлбэр “Морио сауха (морио тэжээнэ, идүүлнэ)” “Малаа сауха (малаа тэжээв, идүүлэв)” гэх утгыг илэрхийлсэн бөгөөд үүнийг монгол хэлнээ орчуулахад зөвхөн “сауха” гэх монгол үгийг өнөө цагт хэрэглээнээс гарсан хуучин үг гэж хадах аваас утга гажуудан ойлгомжгүй болох үүнд заавал зүүлт тайлбар хийвэл зохино.

3. Дах: Монгол хэлний “дах” хэмээх үг нь хүйтэн улиралд хувцасны гадуур үсийг нь гадагш харуулан өмсөх арьсан хувцас, энгэргүй, урдуураа задгай, бүчтэй хувцсыг заадаг. Энэ үг Юань улсын дуурьлигт тухайлбал,

武汉臣《生金阁》剧三折正末白：“...又与你添了一件棉搭護么。” Ү Ханьчэний “Шөн жинь гө” дуурьлигийн гуравдугаар үзэгдлийн Жөн мо өгүүлэх нь: “...чамд дахиад нэг хөвөнтэй дах нөмрүүлсе.”

Өгүүлбэрт “棉搭護 хөвөнтэй дах” гэж орсон нь үндсэн утга болох арьсан хувцас бус хятад үндэсний соёл ахуйд дулдуйдан хөвөнтэй хүрэм гэх үгийг арьсан дах гэх үгээр төсөөлөн, өгүүлбэрт хөвөнгөөр хийсэн “гадуур хувцас” хэмээх утгатай болж хувирсан байна.

Монгол үндэстний соёлын онцлогийг алдагдуулахгүй буюу мэдлэгээ нэгтгэн дүгнэх үүднээс энэхүү өгүүлбэрийг “... чамд дахиад нэг хөвөнтэй дах (арьсан дах 皮搭護, нэхий дах 翻毛皮搭護) нөмрүүлсе.” “арьсан дах 皮搭護, нэхий дах 翻毛皮搭護(” хэмээх монгол үндэстний соёл сэтгэлгээнд агуулах утгыг илэрхийлэх нийлэмж үгээр тайлбар зүүлт хийх нь зүйтэй юм.

Найман зуун гаруй жилийн өмнө цэцэглэн хөгжсөн уран зохиолын нэгэн төрөл болох Юань улсын дуурьлигийн зохиолыг голдуу хятадын шилдэг зохиолч, яруу найрагч нар тухайн үеийн нийгмийн үнэн байдлыг зохиолдоо тусган бичих хэрэгцээ шаардлагын үүднээс хөгжүүлэн бий болгожээ. Өмнө хэвшсэн шүлэг яруу найргийн нөлөө нь ард олны хүлээлтэд хангалтгүй болж ирсэн тул энэ нь хүнийг илүү өдөөсөн, сэтгэл ба нүдийг аль алийг нь баясгах гүн утга бүхий түүхэн үлгэр, домог яриаг агуулан зохиосон дуу хөгжим, бүжиг, ярианы нийлмэл цогц болсон уран зохиолын гайхамшигт өв болж уламжлагдсан юм. Юань улсын дуурьлигийг эхэн үед монголчуудын төвлөн сууж байсан нийслэл хотод монгол хаад язгууртнуудад зориулан тоглодог байсан тул цөөнгүй монгол үгийг зохиолд оруулан хэрэглэсэн байдаг юм.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд Юань улсын дуурьлигийн монгол үг бүхий өгүүлбэрийг жишээ болгон авч үзэж, өгүүлбэрт буй хуучин үгийг түүхэн баримт бичигт суурилан тайлбарлан орчуулах ба тухайн өгүүлбэрт монгол үг орж хэрэглэгдэхдээ утга өөрчлөгдсөн үзэгдэл тухай бүрт зүүлт тайлбар хийх хэрэгтэй болохыг санал болголоо.

Өгүүлэлд "худаг, гудам, гудамж, хишигтэн, морь, буурч, улаач, богтаг" гэх үг бүхий өгүүлбэрт хадгалагдан буй хуучин үгийн тухайн үеийн үндэстний ахуй, соёлын утгыг өнөө цагийн уншигчдад ойлгуулах талаар саналаа дэвшүүллээ. Энэ бол тухайн өгүүлбэрийг орчуулахдаа тайлбар, зүүлт нэмэх, орчуулгын тайлбарлах аргыг ашиглахын зүйтэйг жишээгээр батлан харуулсан явдал юм.

Мөн "худаг, гудамж, сауха, дах" гэх хятад хэлэнд орсон монгол ормол үгийг Юань улсын дуурьлигт буй бодит жишээгээр нотлон үзүүлэв.

Ном зүй

Монгол хэлээр

1. Төмөртоогоо. Д. (2018). Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь, Эрдэм шинжилгээний хэрэглэгдэхүүн, Улаанбаатар.
2. Чимэдцэеэ. М. (2013), Соёл хийгээд орчуулга, Орчуулгазүй, Улаанбаатар
3. Сүхбаатар. О. (1997), Монгол хэлний харь үгийн толь, Улаанбаатар.
4. Сумъяабаатар. Б. (1990), Монголын нууц товчооны үсгийн галиг, Улаанбаатар.
5. Эгшиг. Ш. (2015), Хятадын эртний яруу найраг орчуулах нь, Орчуулгазүй, Улаанбаатар.
6. Оюунзаяа.Н. (2013), Монгол уран зохиолыг англи хэлнээ орчуулсан нь, Орчуулгазүй, Улаанбаатар.
7. Гүрбазар. Р. (1996), “Орчуулгын онол, дадлагын үндэс”, Улаанбаатар.
8. Ж.Баттөр, Орчуулгын эрдэм IV (2012), “Орчуулагчийн тайлбар орон судлалтай холбогдох нь”, Улаанбаатар.

Англи хэлээр

9. Wang nan.(2016), A Study of Wang Hongyin's Translation of Chinese Yuan Qu Poems into English: With Special Reference to 100 Yuan Qu Poems in English.

Хятад хэлээр

10. 方岭贵. (2014), 元明戏曲中的蒙古语, 云南人民出版社, 昆明.
11. 张清常.(1984). 胡同与水井, 语言教学与研究, 北京.
12. 罗常培. (2009). 语言与文化, 北京大学出版社, 北京.

Цахим сурвалж

13. https://baike.baidu.com/item/番/4573828?fr=ge_al
14. <https://baike.baidu.com/item/乡间/6514846>
15. www.mongoltoli.mn